



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/269

Сүхбаатар сум

Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, сорил шинжилгээ хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", "Мал, амьтны эрүүл мэндийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4-6.6, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5, 9.7-9.9, 23 дугаар зүйлийн 23.4, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.19, 1.1.20 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт болон адууны ям, үхрийн сүрьеэ өвчнийг илрүүлэх, оношлох түүвэр тандалт баталгаажуулах шинжилгээг тус тус хийх ажлыг 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаанд чанартай шуурхай зохион байгуулсугай.

2. Сумын хэмжээнд тухайн халдварт өвчнөөр эрсдэлтэй нутаг дэвсгэрийн адуунаас бусад мал сүргийн охин төлийг бүрэн хамруулах, аймгийн хэмжээнд 10000 толгой адуу, 10000 толгой үхэрт сорил шинжилгээ хийх ажлыг сумын Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулж, мал эмнэлгийн улсын байцаагчийн хяналтын дор шуурхай, чанартай зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Био бэлдмэлийг татан төвлөрүүлж тараан олгох болон мэргэжил арга зүй, удирдлага, зөвлөмжөөр ханган, уг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийгдсэн 4-өөс доошгүй суманд тархвар зүйн судалгаа хийж, эпидемиологи аргачлалын дагуу дархлаажуулалтын дараах үр дүнг серио-мониторинг хийж, үр дүнг тооцон, хяналт тавьж, ажлын явц, тайлан мэдээг нэгтгэн, танилцуулж ажиглахыг Мал эмнэлгийн газрын дарга /С.Ариунтөгс/-т үүрэг болгосугай.

5. Уг арга хэмжээний хэрэгжилтэд хариуцлагагүй хандсан иргэд, аж ахуй нэгж, байгууллага, мэргэжилтэнд хуулийн хариуцлага хүлээлгэх хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/, Мал эмнэлгийн газрын дарга /С.Ариунтөгс/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

ШОРГИЛ

